

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 03 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

“Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам” батлах тухай

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаатай холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д даалгасугай.
3. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н. Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЗЭРЭГЛЭЛ ТОГТООХ ЭТГЭЭДЭД ЭРХ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үнэт цаас, зээлжих чадвар, бонд болон түүнтэй адилтгах өрийн бичигт дүн шинжилгээ хийж, эрсдлээр нь ангилан зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, бүртгэх болон түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх хуулийн этгээд өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаасаа үл хамааран зэрэглэл тогтоолгож болно.

1.3. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд Хорооноос батлан гаргасан журам, дүрэм, зааврыг дагаж мөрдөнө.

1.4. Зэрэглэл тогтоох байгууллага нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг чанд баримтална:

1.4.1. Монгол Улсын хууль, тогтоомжийг дээдлэх;

1.4.2. Хараат бус байх;

1.4.3. Иргэн, байгууллагын нууцыг хадгалах;

1.4.4. Ил тод, шударга байх;

1.4.5. Ашиг сонирхлын зөрчилдөөнөөс зайлсхийх;

1.4.6. Компанийн дүрмээ Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос баталсан журам, дүрэм зааварт нийцүүлэх;

1.5. Олон улсад зэрэглэл тогтоох үйл ажиллагаа явуулж буй нэр хүнд бүхий байгууллагад Монгол улсад хуулийн этгээдийн зэрэглэл тогтоох үйл ажиллагаа явуулах эрхийг Хороо олгож болно.

Хоёр. Нэр томъёо

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсанаар ойлгоно:

2.1.1. “Зэрэглэл” гэж хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүний аливаа өр төлбөр, түүнтэй адилтгах өрийн бичгийн ирээдүйд төлбөр төлөх чадварын богино болон дунд хугацааны төлөв байдал, төсөөллийг тодорхойлох замаар тухайн байгууллагад өгсөн үнэлэлт, дүгнэлтийг;

2.1.2. “Зэрэглэл тогтоох байгууллага” гэж зэрэглэл тогтоох арга, аргачлалыг ашиглан аливаа хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүний санхүүгийн байдалд үнэлэлт,

дүгнэлт өгөх зорилгоор байгуулагдаж Хорооноос эрх авч үйл ажиллагаагаа бүртгүүлсэн хуулийн этгээдийг;

2.1.3. “арга, аргачлал” гэж хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүний аливаа өр, төлбөр, түүнтэй адилтгах өрийн бичгээр хүлээсэн үүргээ ирээдүйд биелүүлэх чадварт үнэлэлт, дүгнэлт өгч зэрэглэл тогтоохын тулд эконометрикс, статистик, санхүүгийн шинжилгээ зэргийг ашиглан боловсруулж системчилсэн цогц хэрэгслийг;

2.1.4. “Тэмдэглэгээ” гэж зэрэглэл тогтоох байгууллагаас зэрэглэлээ тогтоолгож байгаа хуулийн этгээдэд өгсөн үнэлэлт, дүгнэлтийн илэрхийллийг тодорхойлсон тэмдэгтийг;

2.1.5. “Ёс зүйн дүрэм” гэж зэрэглэл тогтоох байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон шинжээчийн үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэх зорилгоор тухайн байгууллагаас батлан гаргасан баримт бичгийг;

Гурав. Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх

3.1. Зэрэглэл тогтоох үйл ажиллагааг Хорооноос эрх авч үйл ажиллагаагаа бүртгүүлсэн хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

3.2. Хуулийн этгээд нь Хороонд бүртгүүлэхийн тулд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

3.2.1. Компанийн тухай хуулийн дагуу байгуулагдаж улсын бүртгэлд бүртгүүлсэн байх;

3.2.2. Үйл ажиллагаа явуулах өөрийн эсхүл түрээсийн байртай байх;

3.2.3. Зэрэглэл тогтоох чиглэлээр ажилласан ажлын дадлага туршлагатай 2-оос доошгүй шинжээчтэй байх, эсхүл эдийн засаг, санхүүгийн шинжилгээ, эрсдлийн удирдлагын чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан 4-өөс доошгүй шинжээчтэй байх;

3.2.4. Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага болон шинжээч нар нь санхүү, эдийн засгийн гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;

3.2.5. Гүйцэтгэх удирдлага болон шинжээчээр ажиллах этгээд нь эдийн засаг, банк, санхүү, статистик, эконометрикс, нягтлан бодох, хэрэглээний математикийн чиглэлээр баклавын түвшингээс дээш хэмжээний боловсрол эзэмшсэн байх;

3.2.6. Зэрэглэл тогтоох тусгайлан боловсруулж системчилсэн, эдийн засгийн салбар бүрт тохирсон арга, аргачлалтай байх,

3.2.7. Гүйцэтгэх удирдлага болон шинжээч нь Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан шаардлагыг хангасан байх;

3.2.8. Шинжээчийн ажиллах нөхцөл, шаардлагад нийцсэн албан тавилга, тоног төхөөрөмж /компьютер, принтер, хувилагч, утас, факсийн аппарат/-өөр хангагдсан байх,

3.2.9. Олон нийтэд мэдээлэл хүргэх вэб хуудастай байх;

3.3. Хуулийн этгээд нь зэрэглэл тогтоох эрх авах, үйл ажиллагаагаа бүртгүүлэхдээ дор дурьдсан баримт бичгийг 2 хувь бүрдүүлэн Хороонд албан бичгээр ирүүлнэ:

3.3.1. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт

3.3.2. Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой /холбогдох/ этгээдийн талаарх мэдээлэл, танилцуулга;

3.3.3. Улсын бүртгэлд бүртгүүлсэн Компанийн дүрэм;

3.3.4. Үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, шинжээч нарын талаарх мэдээлэл:

- а/ боловсон хүчний дэлгэрэнгүй анкет;
- б/ Эдийн засаг, банк, санхүү, статистик, эконометрикс, нягтлан бодох, хэрэглээний математикийн чиглэлээр мэргэшсэн диплом, гэрчилгээг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
- в/ ял шийтгэлгүй болохыг нотлосон тодорхойлолт;
- г/ Татварын байгууллагад өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт;

3.3.5. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO – International Organization of Securities Commissions/-аас гаргасан зөвлөмж /Code of Conduct Fundamentals for Credit Rating Agency/-д нийцүүлэн боловсруулсан “Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны үндсэн дүрэм буюу ёс зүйн дүрэм”-ийг батлан ирүүлнэ.

3.3.6. Үйлчлүүлэгчийн дотоод мэдээлэл, баримт материалыг ашиглах, хадгалах, хамгаалах журам;

3.3.7. Тогтоосон зэрэглэлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх журам;

3.3.8. Шинжээчтэй байгуулсан ёс зүйн гэрээ;

3.3.9. Ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, илрүүлэх, түүнээс сэргийлэх журам.

3.3.10. Арга, аргачлал, үзүүлэлт, тэмдэглэгээ, тодорхойлолтын тухай танилцуулга;

3.3.11. Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг, түрээсийн байр бол түрээсийн гэрээг тус тус нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;

3.3.12. Тухайн байгууллагын вэб хуудастайг нотлох баримт болон 1-ээс доошгүй жил тухайн домэйн хаяг эзэмшихийг нотлосон гэрээ, төлбөрийн баримт;

3.3.13. Компанийн санхүүгийн сүүлийн жилийн болон улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

3.3.14. Компанийн техник болон программ хангамжийн талаарх мэдээлэл, танилцуулга, санхүүгийн баримтууд;

3.4. Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх эсэхийг Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.5. Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгон үйл ажиллагааг бүртгэж авсан тухай гэрчилгээг 3 (гурав)-н жилийн хугацаатай олгоно.

3.6. Хороо хуулийн этгээдийн зэрэглэл тогтоох этгээдэд эрх авах, үйл ажиллагаагааг бүртгүүлэх хүсэлт, холбогдох баримт бичгүүдийг бүрэн гүйцэд хүлээн авсанаас хойш 30 хоногт хянаж шийдвэрлэнэ.

3.7. Хэрэв баримт бичгийг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагын улмаас нэмэлт баримт бичиг бүрдүүлж ирүүлсэн өдрийг баримт бичгийг анх хүлээн авсан өдрөөр тооцно.

3.8. Бүртгүүлэхийг хүсч буй хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичгийг дараах тохиолдолд ажлын 10 хоногийн дотор бүртгүүлэхийг хүсэгч этгээдэд буцаана:

3.8.1. Баримтын бичгийн бүрдэл дутуу;

3.8.2. Бүртгүүлэхийг хүсч ирүүлсэн баримт бичиг нь холбогдох хууль болон энэ журамд заасан шаардлагуудыг хангаагүй;

3.9. Хороо шаардлагатай тохиолдолд бүртгүүлэхийг хүсч ирүүлсэн талаар холбогдох байгууллагаас тодруулах, магадлан шинжлүүлэх, лавлагаа авах эрхтэй. Хороо бүртгүүлэхийг хүсч ирүүлсэн баримт бичгийг энэ журмын холбогдох заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгасны үндсэн дээр эрх олгон үйл ажиллагааг бүртгэх болон бүртгэхээс татгалзах асуудлыг шийдвэрлэнэ.

3.10. Эрх олгож, үйл ажиллагааг бүртгэсэн тухай шийдвэрт тухайн байгууллагад санхүүгийн зах зээлд ямар төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг зааж өгнө. Хороо тухайн байгууллагыг бүртгэн авч, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

Дөрөв. Эрх олгон бүртгэхээс татгалзах

4.1. Хороо дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзана:

4.1.1. Энэ журмын 3.2-д заасан нөхцөл, шаардлагыг өргөдөл гаргагч хангаагүй;

4.1.2. хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон;

4.2. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.3. Хороо баримт бичгийг хуурамчаар үйлдсэн гэдэг үндэслэлээр эрх олгох, бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн дотор уг хуулийн этгээдийн хувь нийлүүлэгчид, гүйцэтгэх удирдлагад ажиллах байсан этгээдүүдээс бүртгүүлэхийг хүссэн өргөдлийг дахин хүлээж авахгүй.

Тав. Эрх, үйл ажиллагааны бүртгэлийг сунгах

5.1. Зэрэглэл тогтоох этгээдийн эрх, үйл ажиллагааны бүртгэлийг сунгах эсэхийг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

5.2. Зэрэглэл тогтоох этгээдийн эрх, үйл ажиллагааны бүртгэлийн гэрчилгээг 5 (таван) жилийн хугацаагаар сунгана.

5.3. Зэрэглэл тогтоох байгууллага эрх, үйл ажиллагааны бүртгэлийг сунгуулахдаа энэ журмын 3.3-т заасан баримт бичгийг сунгуулах өргөдлийн хамт бүрдүүлж, бүртгэлийн хугацаа дуусахаас 30 доошгүй хоногийн өмнө Хороонд ирүүлнэ.

5.4. Хороо зэрэглэл тогтоох этгээдийн бүртгэлээ сунгуулахыг хүсч ирүүлсэн баримт бичгийг 30 хоногт хянаж шийдвэрлэнэ.

5.5. Хороо шаардлагатай тохиолдолд сунгуулахаар хүсч ирүүлсэн баримт бичгийн талаар холбогдох байгууллагаас тодруулах, магадлан шинжлүүлэх, лавлагаа авах эрхтэй. Хороо сунгуулахыг хүсч ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль болон энэ журмыг

үндэслэн хянаж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгалт хийсний үндсэн дээр сунгах болон сунгахаас татгалзах асуудлыг шийдвэрлэнэ.

Зургаа. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд тавигдах шаардлага

6.1. Зэрэглэл тогтоох байгууллага нь үйл ажиллагааны үндсэн дүрэм буюу ёс зүйн дүрмийг Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO – International Organization of Securities Commissions/-аас гаргасан зөвлөмж /Code of Conduct Fundamentals for Credit Rating Agency/-д нийцүүлэн боловсруулж, Хороонд ирүүлэн бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаандаа чанд даган мөрдөн ажиллана.

6.2. Зэрэглэл тогтоох байгууллага болон шинжээчид нь Зэрэглэл тогтоох эсхүл эрсдлийн чиглэлийн мэргэжлийн холбооны албан ёсны гишүүнчлэлтэй байна.

6.3. Зэрэглэл тогтоох байгууллага нь эдийн засгийн салбар тус бүрт тохирсон нарийн нягт, системчилсэн өөрийн гэсэн зэрэглэл тогтоох арга, аргачлалтай байх бөгөөд түүнийгээ Хороонд ирүүлж хянуулан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр хуулийн этгээдэд зэрэглэл тогтоохдоо ашиглана.

6.4. Зэрэглэл тогтоох байгууллага нь эдийн засгийн салбар болон үйл ажиллагааны чиглэлд нь тохируулан гаргасан зэрэглэл тогтоох арга, аргачлалаа Хороонд ирүүлж хянуулан холбогдох нэгжээр дүгнэлт гаргуулж Хорооны даргын зөвшөөрлийг үндэслэн үйл ажиллагаандаа ашиглана. /Үнэт цаас гаргагчтай холбогдсон үед Үнэт цаасны газраас, Даатгалын үйл ажиллагаатай холбогдсон үед Даатгалын газраас, Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж, зээлийн хоршооны хуулийн этгээдийн хувьд Бичил, санхүүгийн газраас дүгнэлт гаргуулна./

6.5. Зэрэглэл тогтоох арга, аргачлалд Хороо болон Хорооны дарга хариуцлага хүлээхгүй.

6.6. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүр тогтоосон хугацаанд төлнө.

6.7. Зэрэглэл тогтоох үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа шинжээч нь зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон арга, аргачлалыг нарийн чанд дагаж мөрдөх бөгөөд энэ талаар байгууллагатайгаа гэрээ байгуулсан байна.

6.8. Компанийн талаарх үнэлэлт, дүгнэлт өгөх хангалттай мэдээлэлтэй байж зэрэглэл тогтоох үйл ажиллагааг явуулах бөгөөд зэрэглэл тогтоосон тухай дүгнэлт, тайланг зэрэглэл тогтоох байгууллага гаргаж, хариуцлага хүлээнэ. Харин шинжээч нь энэхүү зэрэглэл тогтоох үйл ажиллагааг бие даан явуулахгүй.

6.9. Зэрэглэл тогтоох үйл явц дахь ашиг сонирхолын зөрчилд авталгүйгээр ажиллаж чадахуйц мэргэжлийн багийг бүрдүүлсэн байна.

6.10. Тогтоосон зэрэглэлээ хуанлийн улиралд 2-оос доошгүй удаа хянан шинэчлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн баг болон санхүүгийн эх үүсвэртэй байна.

6.11. Зэрэглэл тогтоосон багийн ашигласан арга, аргачлалаас өөр арга, аргачлалыг ашиглан харьцуулалт хийх нягтлан шалгах багтай байна. Энэ багийн бүрэлдэхүүнд нэг буюу түүнээс дээш ахлах шинжээч байна.

6.12. Арга, аргачлалаа улирал тутамд эргэж хянах, тэдгээрт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг нягтлан шалгах журмыг тогтоож дотооддоо мөрдөж ажиллана.

6.13. Тогтоож байгаа зэрэглэл нь хязгаарлагдмал түүхэн мэдээллийг илэрхийлсэн бол зэрэглэл нь хязгаарлагдмал болох талаар олон нийтэд мэдээлнэ.

6.14. Зэрэглэл тогтоох байгууллага болон түүний ажилчид нь санхүүгийн зах зээлийн оролцогчид, олон нийттэй шударга, ил тод харилцана. Шинжээчид нь ил тод байх журмыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авдаг тогтолцоог бий болгосон байна.

6.15. Зэрэглэл тогтоох байгууллага нь аливаа нэг хуулийн этгээд, хувь хүнээс хараат бус байдлаар бие даан ажиллаж, ашиг сонирхлын зөрчилд авталгүйгээр зэрэглэл тогтоох үйл ажиллагааг явуулна.

6.16. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд нөлөөлж болох удирдлагын баг, шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийг /1/ таньж мэдэх, тодорхойлох /2/ арилгах, илрүүлэх гэсэн чиглэл бүхий бичгээр хэлбэржсэн дотоод журам, дүрэм болон механизмтай байна.

6.17. Тогтоосон зэрэглэлийн тэмдэглэгээг олон нийтэд хэвлэн нийтэлж мэдээлэх үүрэгтэй.

6.18. Тогтоосон зэрэглэлийн тэмдэглэгээг олон нийтэд мэдээлэхдээ уг тэмдэглэгээний талаар Төрийн зохицуулалтын болон захиргааны аливаа нэг байгууллага хариуцлага хүлээхгүй бөгөөд тухайн зэрэглэл тогтоох байгууллага бүрэн хариуцлага хүлээх талаар заавал дурьдсан байна.

6.19. Дотоод мэдээлэл ашиглах эрхтэй хүмүүсийн талаарх мэдээлэл, тэдэнтэй байгуулсан нууцлалын гэрээг Хороонд гаргаж ирүүлнэ.

6.20. Санхүүгийн зах зээлд оролцогчдын талаар мэдээллийн бааз үүсгэж, мэдээллийг 5-аас доошгүй жил хадгалах бөгөөд төрөл бүрийн халдлага /санаатай болон санамсаргүй төрлийн халдлага/-аас урьдчилан сэргийлнэ.

6.21. Тогтоосон зэрэглэлээ сард 2-оос доошгүй удаа өдөр тутмын 2-оос доошгүй олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд эсхүл зэрэглэл тогтоох байгууллагаас гаргаж байгаа сонин, сэтгүүлд хэвлэн нийтлэнэ. Энэхүү мэдээллийг хэвлэн нийтлүүлэхээс 2 хоногийн өмнө Хороонд ирүүлж байна.

6.22. Зэрэглэлд өөрчлөлт оруулсан үед ажлын 1 өдрийн дотор байгууллагынхаа вэб хуудсанд тавьж олон нийтэд мэдээлнэ. Ийнхүү өөрчлөлт оруулсан тохиолдолд өдөртөө багтаан Хороонд мэдэгдэнэ.

Долоо. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд хориглох зүйлс

7.1. Зэрэглэл тогтоох байгууллага нь Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай бүртгэлийн тухай журам”-ын 1.2.8-д заасан хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.

7.2. Зэрэглэл тогтоох үйл явцад олж авсан нууцын зэрэглэлтэй мэдээ, мэдээлэл, тайлан, баримт бичгийг найдвартай хадгалан хамгаалж, аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй байх бөгөөд зөвхөн Хорооноос шаардсан үед тэдгээрийг гаргаж өгнө.

7.3. Зэрэглэл тогтоох байгууллага нь компанийн зээлжих чадвар болон өр төлбөрийн талаар олон нийтийг төөрөгдүүлсэн, худал мэдээлэл агуулсан тайлан, дүн шинжилгээ гаргахыг хориглоно.

7.4. Зэрэглэл тогтоож байгаа шинжээч нь олж авсан мэдээлэл, баримт бичиг, мэдээ, мэдээллийг бусад этгээдтэй хуваалцахыг хориглоно.

7.5. Шинжээч нь зэрэглэл тогтоолгож байгаа компанийн хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтантай холбогдох этгээд байхыг хориглоно. Энэ тохиолдолд шинжээч нь энэ талаар удирдлагадаа мэдэгдэх бөгөөд тухайн зэрэглэл тогтоох үйл явцад оролцуулахыг хориглоно.

7.6. Зэрэглэл тогтоох байгууллагын зэрэглэл тогтоох үйл явцад үүссэн эсхүл үүсч болох аливаа харилцаа нь зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөх ёсгүй бөгөөд үүнд бусад этгээдтэй харилцах харилцаа ч хамаарна.

7.7. Зэрэглэл тогтоохдоо зөвхөн хамаарах хүчин зүйлүүдийг авч үзэх бөгөөд харин эдийн засаг, улс төрийн бүлэглэл болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөр зэрэглэл тогтоохыг хориглоно.

Найм. Зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх

8.1. Зэрэглэл тогтоолгох хүсэлтэй хуулийн этгээдийн захиалгаар эсхүл дотоод ажлын хэрэгцээнд зориулан компанийн зэрэглэлийг тогтооно.

8.2. Зэрэглэл тогтоох, түүнийг шинэчлэх, хянах, нягтлах ур чадвар бүхий мэргэшсэн багтай, шаардагдах мэдээллийг захиалагчаас бүрэн гаргуулан авах боломжтой гэж үзсэн тохиолдолд үйлчлүүлэгчийн зэрэглэл тогтоох хүсэлтийг хүлээн авна.

8.3. Зэрэглэл тогтоолгохоор захиалга өгсөн хуулийн этгээдтэй Иргэний хуулийн 31 дүгээр бүлгийг баримтлан гэрээ байгуулах бөгөөд тухайн гэрээнд талуудын хүлээх эрх, үүргийг нарийвчлан тусгаж хувийг Хороонд ирүүлнэ.

8.4. Захиалгаар зэрэглэл тогтоох үйл ажиллагаа нь дараах шаардлагад нийцсэн байна:

8.4.1. Зэрэглэл тогтоолгох гэрээг үйлчлүүлэгчтэй байгуулсан байх;

8.4.2. Зэрэглэл тогтоох стандарт, арга, аргачлал, журам, дүрэм болон шаардлагатай бусад баримт бичгийг бэлтгэсэн байх;

8.4.3. Зэрэглэл тогтоох чиглэлээр мэргэшсэн ажлын багийг томилсон байх;

8.4.4. Зэрэглэл тогтоох төлөвлөгөө, хуваарийг боловсруулж, баталсан байх;

8.4.5. Зэрэглэл тогтооход шаардагдах баримт бичгийг үйлчлүүлэгчээс гаргуулан авсан байх;

8.4.6. Зэрэглэл тогтооход ашиглаж байгаа мэдээллийн сан, үйлчлүүлэгчээс ирүүлсэн тоо, мэдээг дахин хянаж, магадлан шинжилсэн байх;

8.5. Дотоод ажлын хэрэгцээнд зориулсан зэрэглэл тогтоох ажил нь дараах шаардлагад нийцсэн байна:

8.5.1. Зэрэглэл тогтоох хуулийн этгээдийг түүврийн аргаар санамсаргүй байдлаар сонгосон байх;

8.5.2. Тусгайлан боловсруулсан, олон нийтийн хүртээл болгосон зэрэглэл тогтоох арга, аргачлалаар явуулсан байх;

8.5.3. Энэ чиглэлээр ажиллах мэргэшсэн ажлын багийг томилсон байх;

8.5.4. Тогтоосон зэрэглэлд эргэн хяналт хийх хуваарийг боловсруулж баталсан байх;

8.5.5. Зэрэглэл тогтооход ашиглаж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичгийг дахин хянаж, магадлан шинжилсэн байх;

Ес. Үйлчилгээний үнэ хөлс

9.1. Захиалгаар зэрэглэл тогтоосон үйлчилгээний хөлсийг энэ журмын 8.3-т заасан талуудын хооронд байгуулах гэрээнд тусгана.

9.2. Зэрэглэл тогтоох үйлчилгээ нь ажлын цар хүрээнээс хамаарч хэд хэдэн төрөл байж болох бөгөөд төрөл тус бүрийн үйлчилгээний хөлсийг өөрөөр тогтооно. Үйлчилгээний хөлс тогтоож нийтэд үйлчилгээ үзүүлж эхлэхээс өмнө Хороонд үйлчилгээний төрөл, жишиг үнийг урьдчилан мэдэгдэх бөгөөд үйлчилгээний хөлсний талаар вэб хуудас, байгууллагын танилцуулгад заавал тусгана.

9.3. Ижил төрлийн үйлчилгээг тогтоосон нэг үнээр гүйцэтгэнэ. Нэмэгдэл төлбөр авах замаар зэрэглэлийг захиалагчийн хүсэлтээр гаргаж өгөх, өөрчлөхийг хориглоно.

9.4. Үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжээс авсан төлбөрийн талаар зэрэглэл тогтоосон тайланд тусгана.

9.5. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд хамааралгүй үйлчилгээнд /зөвөлгөө өгөх г.м./ үйлчлүүлэгчээс нэмэлт хөлс авсан тохиолдолд зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд авсан хөлс болон зэрэглэл тогтоох үйл ажиллагааны бус хөлсний талаар зэрэглэл тогтоосон тайланд дурьдана.

9.6. Хийх ажлын төрөл, үйлчилгээний үнэ, хөлс нь үйлчлүүлэгчид тодорхой байх бөгөөд үүнийг тухайн байгууллага нь өөрийн вэб хуудас болон танилцуулгад оруулна.

9.7. Тайлангийн жилийн эцэст зэрэглэл тогтоох үйл ажиллагаанаас орж ирсэн орлого тухайн компанийн жилийн нийт орлогын хэдэн хувийг эзэлж байгаа, мөн ямар төрлийн үйлчилгээнээс зэрэглэл тогтоох ажлын орлого нь бүрдэж байгаа тухай тайлан гаргаж Хороонд ирүүлэхээс гадна өөрийн вэб хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

9.8. Хэрэв нэг үйлчлүүлэгчээс орж ирсэн орлого зэрэглэл тогтоох үйл ажиллагаанаас олсон орлогын 10 хувиас дээш бол энэ талаар заавал дурьдана.

Арав. Зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэхээс татгалзах

10.1. Дараах хуулийн этгээдийн зэрэглэл тогтоолгох хүсэлтийг зэрэглэл тогтоох байгууллага хүлээн авахаас татгалзана:

10.1.2. Сүүлийн 2 жилд гүйцэтгэх удирдлага нь ажиллаж байсан хуулийн этгээдийн;

10.1.2. Гүйцэтгэх удирдлага болон шинжээч нь сүүлийн 2 жилийн дотор эд хөрөнгийн талаар /компанийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байсан, эсхүл зээл, төлбөр болон хөрөнгө оруулалтын талаар харилцаатай/ холбоотой байсан буюу холбоотой байгаа хуулийн этгээдийн;

10.1.3. Ойрын төрөл садан /эцэг, эх, нөхөр, эхнэр, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү нар/ нь эрх бүхий албан тушаалтан /төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч/-наар ажилладаг хуулийн этгээдийн;

10.1.4. Зэрэглэл тогтоох байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлсэн болон үзүүлж байгаа хуулийн этгээдийн;

10.1.5. Өөрийн байгууллага болон нэгдмэл сонирхолтой /холбогдох/ этгээдэд зэрэглэл тогтоож болохгүй бөгөөд энэ талаар өөр бусад байгууллагад хандана.

Арван нэг. Зэрэглэл тогтоосон тухай тайлан

11.1. Зэрэглэл тогтоосон тайлан нь ашигласан арга, аргачлалын талаар дурьдсан, ашигласан санхүүгийн тайлан, түүнийг үндэслэн тогтоосон зэрэглэлийн талаарх тэмдэглэгээ, тодорхойлолт, нотолгоог агуулсан баримт бичиг байна.

11.2. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаа явуулсан болон өөрчлөлт оруулсан тайланг зэрэглэл тогтоож дуусснаас 7 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

11.3. Зэрэглэл тогтоосон тайланд дараах зүйлсийг тусгана:

11.3.1. Зэрэглэл тогтооход ямар арга, аргачлал ашигласан талаар тодорхой дурьдах;

11.3.2. Зэрэглэлийн тэмдэглэгээ, түүний тодорхойлолт;

11.3.3. Зэрэглэл тогтоосон багийн гишүүдийн нэр, ажлын дадлага туршлага;

11.3.4. Зэрэглэл тогтоосон багийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилд авталгүйгээр хараат бус байдлаар ажилласан тухай баталгаа;

11.3.5. Үйлчлүүлэгчийн нэр, хаяг, регистрийн буюу улсын бүртгэлийн дугаар болон шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

11.3.6. Зэрэглэл тогтоосон үндэслэл, зориулалт;

11.3.7. Зэрэглэл тогтоосон ажлын хугацаа болон тайлангийн огноо;

11.3.8. Зэрэглэл тогтоосон ажилд хамрагдсан хүрээ,
11.3.9. Зэрэглэл тогтоосон тайланг хэрэглэх, ашиглах хязгаар;
11.3.10. Зэрэглэл тогтооход ашигласан баримт, бичиг, мэдээ мэдээлэл,
дэвшүүлсэн таамаглал;

11.4. Зэрэглэл тогтоосон тайланд зэрэглэл тогтоох байгууллагын удирдлага болон шинжээч нар гарын үсэг зурж, байгууллагын тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

Арав хоёр. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулах, байгууллагын оноосон нэрийг өөрчлөх, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх

12.1. Зэрэглэл тогтоох байгууллага нь Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулах, байгууллагын оноосон нэрийг өөрчлөх, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөхдөө Хороонд мэдэгдэж бүртгүүлнэ.

12.2. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулах бүрдээ Хорооноос зөвшөөрлийг авах бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

12.2.1. Өөрчлөлт оруулах хүссэн үндэслэл бүхий албан бичиг;

12.2.2. Тухайн байгууллагын хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд шинээр орж буй хувь нийлүүлэгчийн хувьд энэ журмын 3.3.4-д заасан баримт бичиг, дүрмийн санд оруулах хөрөнгө нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг;

12.2.3. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад тухайн байгууллагын дүрэмд орох нэмэлт өөрчлөлт;

12.3. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг Хороо энэ журмын холбогдох заалтыг үндэслэн хянаж, шаардлагатай асуудлыг газар дээр нь шалгасны үндсэн дээр санал, дүгнэлт гарган Хорооны даргад танилцуулна. Хороо холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн зэрэглэл тогтоох байгууллагын хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулах эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

12.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах нь зэрэглэл тогтоох байгууллагын санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, бусад хувь нийлүүлэгч, харилцагчдад хохирол учруулахгүй гэж үзвэл Хороо хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах зөвшөөрлийг олгож болно.

12.5. Зэрэглэл тогтоох байгууллага нь оноосон нэрээ өөрчлөхийг хүсвэл Хороонд өргөдөл гаргах бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ:

12.5.1. Байгууллагын оноосон нэрийг өөрчлөх тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

12.5.2. Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан шинэ оноосон нэрийн тодорхойлолт;

12.5.3. Байгууллагын дүрэмд оруулах өөрчлөлт;

12.5.4. Шаардлагатай бусад баримт бичиг.

12.6. Зэрэглэл тогтоох байгууллагын оноосон нэр солих хүсэлтийг хянаж, оноосон нэрийг өөрчлөх нь тухайн байгууллагын харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн зэрэглэл тогтоох байгууллагын оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн тухай шийдвэрийг Хороо гаргана.

12.7. Зэрэглэл тогтоох байгууллагын оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төлсөн баримтыг үндэслэн Хорооноос олгосон бүртгэлийн гэрчилгээг хураан авч, шинээр бүртгэлийн гэрчилгээг олгоно.

12.8. Байгууллагын гүйцэтгэх захирлыг томилохдоо Хорооноос бичгээр зөвшөөрөл авна. Хорооноос бичгээр зөвшөөрөл авахдаа 3.5.4-т заасан бичиг баримтыг бүрдүүлж ирүүлэхээс гадна гүйцэтгэх захирлыг томилж, өөрчилж байгаа шийдвэр, тайлбарыг хавсаргана.

12.9. Гүйцэтгэх захирлаар томилохоор санал болгож байгаа этгээд нь зэрэглэл тогтоох байгууллагыг удирдах мэдлэг боловсрол, дадлага туршлага, ёс зүйн хувьд хангасан гэж үзвэл тус этгээдийг томилох зөвшөөрлийг Хороо олгоно.

Арван гурав. Бүртгэлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох хасах

13.1. Хороо дараах үндэслэлээр зэрэглэл тогтоох байгууллагын эрх, үйл ажиллагааны бүртгэлийг түтгэлзүүлнэ:

13.1.1. Зэрэглэл тогтоосон хуулийн этгээдийн зэрэглэлийн тэмдэглэгээг 5-аас дээш удаа ирүүлээгүй;

13.1.2. Тогтоосон зэрэглэлийн талаар олон нийтэд 3-аас дээш мэдээлээгүй;

13.1.3. Ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 4 улирал дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

13.1.4. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний жилийн хөлсийг төлөх хугацааг 3-аас дээш сараар хэтрүүлсэн;

13.1.5. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл,

13.2. Хороо дараах үндэслэлээр зэрэглэл тогтоох байгууллагын бүртгэлийг хүчингүй болгож, бүртгэлээс хасна:

13.2.1. Зэрэглэл тогтоох байгууллага хүсэлт гаргасан;

13.2.2. Энэ журамд заасан хугацаанд бүртгэлээ сунгуулах хүсэлтээ ирүүлээгүй;

13.2.3. Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд төлөлгүй 1 жил болсон;

13.2.4. Зэрэглэл тогтоох байгууллага дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон буюу татан буугдсан тухай эрх бүхий байгууллага болох шүүх, тухайн байгууллагын хувь нийлүүлэгчдийн хурлаас зарласан;

13.2.5. Олон нийтийг төөрөгдүүлсэн хуурамч мэдээллийг удаа дараа гаргасан нь нотлогдсон;

13.2.6. Зэрэглэл тогтоох байгууллага нь 10-аас дээш хуулийн этгээдийн зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд энэхүү журам болон байгууллагын зэрэглэл тогтоох журам, дүрмийг баримтлалгүй зэрэглэл тогтоосон нь нотлогдсон;

13.2.7. Зэрэглэл тогтоохдоо захиалагч болон гуравдагч этгээдийн захиалгаар санаатайгаар зэрэглэлийг буруу тогтоосон нь нотлогдсон;

13.2.8. Зэрэглэл тогтоох байгууллага нь Хороонд бүртгүүлснээс хойш 6 сараас дээш хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;

13.2.9. Ирүүлбэл зохих санхүүгийн тайлан мэдээг 6 улирал дараалан Хороонд гаргаж өгөөгүй;

13.2.10. Бүртгэлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, энэ хугацаанд тухайн үйл ажиллагааг үргэлжлүүлэн эрхэлсэн, гаргасан зөрчлөө бүрэн арилгаагүй;

13.2.11. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

13.3. Бүртгэлийг хүчингүй болгон хасах тохиолдолд бүртгэлийн гэрчилгээг хураан авч, “ХҮЧИНГҮЙ” тэмдэг дарж тухайн байгууллагын хувийн хэрэгт хавсарган, холбогдох журмын дагуу архивт шилжүүлнэ.

13.4. Бүртгэлийг хүчингүй болгож бүртгэлээс хассан тохиолдолд Хороо болон тухайн зэрэглэл тогтоох байгууллага хамтарч Ажлын хэсэг гарган зэрэглэл тогтоосон үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэж Үндэсний архивийн газарт шилжүүлнэ.

13.5. Хороо зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэхээр олгосон бүртгэлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

13.6. Бүртгэл нь хүчингүй болж бүртгэлээс хасагдсан зэрэглэл тогтоох байгууллагын нэрийг тухайн байгууллагад ажиллаж байсан этгээд болон өөр бусад хуулийн этгээд ашиглахыг хориглоно.

13.7. Бүртгэлийг түдгэлзүүлсэн тохиолдолд түдгэлзүүлсэн үндэслэл болсон зөрчил дутагдлыг арилгаж, хэвийн үйл ажиллагааг хангасан гэж үзвэл тухайн байгууллага бүртгэлээ сэргээлгэх хүсэлтийг Хороонд гаргаж болно.

13.8. Хорооноос түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан гэж үзвэл бүртгэлийг сэргээнэ. Хэрэв хүсэлт гаргаагүй тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгоно.

Арван дөрөв. Хяналт, шалгалт, хариуцлага

14.1. Хороо нь зэрэглэл тогтоох байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж хариуцлага тооцох эрхтэй.

14.2. Зэрэглэл тогтоох байгууллагын дараах үйл ажиллагаанд зайнаас болон газар дээр нь хяналт тавина.

14.2.1. Зэрэглэл тогтоох байгууллагын үйл ажиллагааны үндсэн дүрэм буюу ёс зүйн дүрмийн хэрэгжилт;

14.2.2. Зэрэглэл тогтоох байгууллагаас батлан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах ёстой дүрэм, журам, заавар, гэрээ, тэдгээрийн хэрэгжилт;

14.2.3. Захиалагчтай байгуулсан гэрээ;

14.2.4. Зэрэглэл тогтоох байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа;

14.2.5. Зэрэглэл тогтоох шалгуур үзүүлэлт;

14.2.6. Бие даасан хараат бус үйл ажиллагаа;

14.2.7. Ашиг сонирхлын зөрчил;

14.2.8. Зэрэглэл тогтоох үйл ажиллагаа;

14.2.9. Зэрэглэл тогтоох багийн зэрэглэл тогтоож байгаа үйл явц;

14.2.10. Дотоод мэдээллийг ашиглах, хадгалах, хамгаалах үйл явц;

14.2.11. Боловсруулсан мэдээ, мэдээлэл, тайлан;

14.2.12. Олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа;

14.2.13. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад баримт.

14.3. Хорооноос хийсэн шалгалтаар энэхүү журмын 13.2.5-13.2.7-д заасан үндэслэл нотлогдсон тохиолдолд тухайн зэрэглэл тогтоох байгууллагын бүртгэлийг хүчингүй болгож Хорооны бүртгэлээс хасна.

14.4. Хороо энэ журмын 13.2.5-13.2.7-д заасан үйл ажиллагаанд оролцсон шинжээчийг зэрэглэл тогтоох үйл ажиллагаанд оролцохыг 5-аас доошгүй жилээр хориглох бөгөөд тухайн шинжээч нь хориг дууссаны дараа Зэрэглэл тогтоох эсхүл эрсдлийн чиглэлийн мэргэжлийн холбооноосоо зөвшөөрөл авсны үндсэн дээр Хороонд хандан хоригийг цуцлуулах хүсэлтийг тавьж болно.

14.5. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО